

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 04 сарын 14-ны өдөр

Дугаар А/178
149

Улаанбаатар хот

Заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Магнайсүрэн/ нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 74/37 дугаар хамтарсан тушаалыг хүчингүйд тооцсугай.





УС ХАНГАМЖ, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙН СҮЛЖЭЭНД ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хот, суурины хүн амын ундны ус, хаягдал бохир усыг бохирдуулах хүчин зүйлүүдийг тогтоож, бохирдлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлох, эрсдэлийг үнэлэхэд энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Энэхүү заавраар ундны ус, хаягдал бохир усанд эрсдэлийн үнэлгээ хийхтэй холбоотой асуудлыг зохицуулна.

Хоёр. Хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим

2.1. Аймаг, нийслэл болон төвлөрсөн ус хангамжтай сумын төвүүдэд "Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө" /цаашид "төлөвлөгөө" гэх/-г боловсруулна.

2.2. Төлөвлөгөөг боловсруулахдаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан "Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг улсын түвшинд хэрэгжүүлэх хөтөч", "Хот, суурин газрын ус хангамжийн тогтолцоонд усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах гарын авлага", "Ариун цэврийн байгууламжид аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах гарын авлага"-ыг ашиглана.

2.3. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ бүрийн хугацаа, түүнд шаардагдах зардал, хариуцах байгууллагыг урьдчилан тогтооно.

2.4. Төлөвлөгөөнд тодорхой үзүүлэлтүүдийг илэрхийлсэн хүснэгт, дүрслэл, бүдүүвч зураг, зураглалыг өргөн хэрэглэж болно.

2.5. Төлөвлөгөөнд хэрэгжүүлэх явц болон хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд тусгагдсан байна.

2.6. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тохиолдож болох эрсдэлүүдийг урьдчилан тооцон, тэдгээрээс сэргийлэх, хор уршгийг арилгах ажлын менежментийг төлөвлөн ажиллана. Шаардлага гарсан тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулахын зэрэгцээ үйл ажиллагаа тасралтгүй үргэлжлэх шинж чанарыг хадгална.

Гурав. Төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд

3.1. Олон нийтийн оролцоог хангах, баг бүрдүүлэх

3.1.1.Төлөвлөгөө хэрэгжүүлэх байгууллага нь шийдвэр гаргагч эрх бүхий этгээд болон иргэдэд төлөвлөгөөний ач холбогдлыг ойлгуулан, олон нийтийн дэмжлэг авсан байна.

3.1.2.Оршин суугчдын төлөөллийг усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх багт заавал оролцуулна.

3.1.3.Багийн гишүүд нь усны олборлолт, цэвэршүүлэлт, түгээлт зэрэг усыг олборлохоос хэрэглэгчид хүрэх хүртэлх бүхий л үе шатанд усны чанар, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдэлт хүчин зүйлсийн талаар зохих мэдлэг, туршлагатай байна.

3.1.4.Багийн бүрэлдэхүүнийг нийслэлд Ус сувгийн удирдах газрын дарга, орон нутагт аймаг, сумын Засаг дарга томилно. Нийслэлд багийн ахлагч, нарийн бичгийн даргыг Ус сувгийн удирдах газрын дарга томилно. Орон нутагт багийн ахлагчаар аймаг, сумын Засаг даргын орлогч, нарийн бичгийн даргаар хангагч байгууллагын дарга ажиллана. Баг нь 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

3.1.5.Тухайн хангагч байгууллагын үйлчлэх хүрээ, хүн амын тооноос хамаарч төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх дэд багтай байж болно.

3.2.Төлөвлөгөөг боловсруулах үйл явц

3.2.1.Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний зорилго нь хот, суурины хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар тасралтгүй, найдвартай хангах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэхэд оршино.

3.2.2.Төлөвлөгөөг боловсруулахын тулд өмнө нь хэрэгжиж байсан төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө болон ус хангамж, ариун цэврийн байгууламжийн мэдээллийн нэгдсэн сантай танилцсан байна.

3.2.3.Төлөвлөгөө боловсруулахдаа урт, дунд болон богино хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлж, үе шаттайгаар төлөвлөж, түүнд шаардагдах хөрөнгө, хэрэгжүүлэх хугацаа, хүрэх үр дүн, хэрэгжилтийг хариуцах байгууллагын хамт тусгана. Төлөвлөгөөг цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж байх хэрэгтэй.

3.2.4.Аймаг, нийслэл, сумдад төлөвлөгөө боловсруулах боловсон хүчин, техник хангамж, шинжилгээ хийх лабораторын чадавхи, хэрэгжүүлэх боломжийг тухайн хангагч байгууллага бүрдүүлнэ.

3.2.5.Хангагч байгууллага нь эрсдэлийн үнэлгээнд суурилсан хөрөнгө оруулалтын тооцоог гарган төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар жил бүр хэлэлцүүлж, батлуулна.

3.2.6.Хангагч байгууллага нь төлөвлөгөөний хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх тайланг жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүрд нь аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж, тайлагнана.

3.2.7.Нийслэлд Нийслэлийн Засаг даргын тамгын газар, орон нутагт аймгийн Засаг даргын тамгын газар нь төлөвлөгөөний хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх тайланг Эрүүл мэндийн болон Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтран баталсан “Ус, ариун цэврийн байгууламжийн ажлын хэсэгт /цаашид “ажлын хэсэг” гэх/ жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр хүргүүлж, тайлагнана.

3.3. Ажлын хэсэг нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.3.1.Багийг чадавхижуулах, гадаад, дотоодын сургалтад хамруулах, туршлага судлах;

3.3.2.Үндэсний зөвлөх болон сургагч багшийг 2 жил тутамд давтан сургах;

3.3.3.Төлөвлөгөөний үе шат бүрт зөвлөгөө, зааварчилгаа өгөх;

3.3.4.Үндэсний онцлогт тохируулан амжилттай хэрэгжсэн орон нутгийн туршлагыг сурталчлах, дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах;

3.3.5.Гарын авлага, холбогдох материалыг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.3.6.Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг авах, нэгтгэх, гарсан үр дүнг хэлэлцэн, холбогдох яамдыг мэдээллээр хангах;

3.3.7.Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллага, холбоо, их дээд сургуулиудтай хамтран ажиллах;

3.3.8.Хүн амын унд, ахуйн ус хангамжтай холбоотой бодлогын баримт бичигт үнэлгээ хийж, санал зөвлөмж боловсруулан, холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх;

3.3.9.Төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлсэн хангагч байгууллагыг дэмжих, урамшуулах талаар хууль эрх зүйн орчинд зохицуулалт хийнэ.

Дөрөв. Эрсдэлийн үнэлгээ хийх

4.1.Үнэлгээг хийхийн тулд тухайн нутаг дэвсгэрийн газар зүйн онцлогийг тодорхойлсон дараах мэдээллүүдийг агуулсан зураглал, схемийг боловсруулсан байна. Үүнд:

4.1.1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт байрлах ус хангамж, бохир ус, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн байршлын схем;

4.1.2.Харьяалагдах сав газрын нэр;

4.1.3.Газар зүйн мужлал, солбилцол;

4.1.4.Ус хангамжийн эх үүсвэрийн талбайн хэмжээ;

4.1.5.Газар эзэмшлийн хил хязгаар;

4.1.6.Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, хүчин чадал, ус цэвэршүүлэлтийн үзүүлэлтүүд, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

4.1.7.Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийн орчинд байрлаж байгаа бусад объектуудын байршил, зай хэмжээ;

4.1.8.Орчны тойм зураг.

4.2.Зураглалд эх үүсвэрээс хэрэглэгч хүртэлх төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжийг бүхэлд нь хамруулах ба дараах мэдээллүүдийг тусгасан байна. Үүнд:

4.2.1.Усны эх үүсвэр, ариутгах татуургын сүлжээнд гамшиг (ноцтой байдал) үүссэн үед ашиглах нөөц эх үүсвэр;

4.2.2.Цаг уурын болон бусад нөхцөл байдлын улмаас эх үүсвэр, усны чанарт гардаг буюу гарч болзошгүй өөрчлөлт;

4.2.3.Эх үүсвэр ба нөхцөл байдлын хоорондын хамаарал байдаг эсэх;

4.2.4.Сав газрын газар ашиглалтын байдал;

4.2.5.Олборлолтын цэг;

4.2.6.Цэвэр, бохир усны чанарын шинжилгээний дүн;

4.2.7.Усны хадгалалтын талаарх мэдээлэл;

4.2.8. Ундны усны чанар сайжруулах болон бохир усыг цэвэрлэх байгууламж, тэдгээрийн хүчин чадал, цэвэрлэгээний арга, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түүнд шаардагдах химийн бодис, урвалж болон бусад материалуудын талаарх мэдээлэл;

4.2.9. Ус дамжуулах, түгээх шугам хоолой, усан сан, өргөлтийн насосны станц, ус түгээх байрны талаарх мэдээлэл;

4.2.10. Ус хэрэглэгч, ус хэрэглээний талаарх мэдээлэл;

4.2.11. Бохир усыг цуглуулах, татан зайлуулах, зөөвөрлөх, цэвэрлэх, бохир усыг дахин ашиглах талаарх мэдээлэл;

4.2.12. Боловсон хүчний хангамж, сургалт дамжаанд хамрагдсан талаарх мэдээлэл;

4.2.13. Үйл явцыг хэрхэн баримтжуулдаг тухай мэдээлэл.

4.3. Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын бүхий л бүрэлдэхүүн хэсгийг хамруулсан технологийн бүдүүвч схемийг боловсруулна. Бүдүүвч схемд дараах бүрэлдэхүүн хэсэг тус бүрийг хариуцах байгууллагын хамт тодорхой тусгана. Үүнд:

4.3.1. Усны эх үүсвэр;

4.3.2. Ус олборлох үйл явц;

4.3.3. Усны барилга байгууламж;

4.3.4. Усны чанар сайжруулах үйл явц;

4.3.5. Ус дамжуулах, түгээх шугам хоолой, тэдгээрийн байршил;

4.3.6. Усны нөөцийн савны хийц, материал;

4.3.7. Ус түгээх байр, ус зөөврийн машин бусад;

4.3.8. Бохир ус цуглуулах шугам сүлжээ, насосны станцын байгууламж, цэвэрлэх байгууламж;

4.3.9. Бохир усыг зөөвөрлөх тусгай зориулалтын автомашин;

4.3.10. Хэрэглэгч.

4.4. Төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тэдгээрийн хэвийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг тасалдуулан, бохирдуулж болзошгүй аюулт хүчин зүйл, аюулт үзэгдэлүүдийг хээрийн болон баримтын судалгаагаар урьдчилан тогтооно. Үүнд:

4.4.1. Ус хангамжийн эх үүсвэрт;

4.4.2. Усны чанар сайжруулах үе шатанд;

4.4.3. Дамжуулах, түгээлтийн шугам сүлжээ болон зөөвөрлөх, тээвэрлэлтийн явцад;

4.4.4. Бохир усыг цуглуулах, татан зайлуулах шугам хоолой болон зөөвөрлөх явцад;

4.4.5. Бохир усыг цэвэрлэх үе шатанд;

4.4.6. Хэрэглэгчийн буюу өрхийн түвшинд.

4.5. Гэнэтийн аюул нүүрлэх болон түүний үр дагавар хэр ноцтой болохыг харгалзан эрсдэлийг эрэмбэлж, үнэлгээ өгнө.

4.6. Бүх эрсдэлийн үнэлгээг баримтжуулж, давтамж нь ховор, эрсдэлийн зэрэг бага байсан ч тогтмол хугацаанд давтан үнэлж байна.

4.7.Тогтоосон эрсдэлүүдийг бууруулах, гарсан үнэлгээний дагуу арилгахад чиглэсэн хяналтын арга хэмжээг тодорхойлж, сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

Тав. Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ

5.1.Хангагч байгууллага нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амыг стандартын шаардлагад нийцсэн ундны усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг цуглуулан татан зайлуулах үйл ажиллагааг тасралтгүй, найдвартай зохион байгуулах чадамжтай эсэхийг баталгаажуулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

5.2.Тодорхойлсон аюулт үзэгдэл, аюултай хүчин зүйлүүдийг хянах, хяналт хийх давтамж, байршил, хариуцах этгээдийг тодорхой тусгасан хяналт-шинжилгээний төлөвлөгөөтэй байна.

5.3.Төлөвлөгөөний хэрэгжилтийн өдөр тутмын хяналтыг хангагч байгууллага, хөндлөнгийн хяналтыг баг, ажлын хэсэг, холбогдох мэргэжлийн болон хяналтын байгууллага хяналт тавьж, гадаад, дотоод аудит хийлгэж байна.

5.4.Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг улиралд нэг удаа авч, төлөвлөгөөнд тусгана.

5.5.Төлөвлөгөөг боловсруулах явцад цуглуулсан мэдээлэл, туршлага, хэрэглэгчдээс ирүүлсэн санал, гомдлыг бүртгэн, баримтжуулна.

5.6.Төлөвлөгөөний үр дүн, хэрэгжилт, эрсдэлийн байдалд жил бүр тойм үнэлгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээ авч, тайлан гаргаж байна.

5.7.Төлөвлөгөөг шинэчлэхдээ ач холбогдлоор нь эрэмблэн, үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөнө.

5.8.Төлөвлөгөө, заавар, зөвлөмж бусад баримт бичгүүдийг он дарааллаар архивлана.

5.9.Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн талаарх засвар үйлчилгээ, хяналт шалгалтын материалыг хадгална.

5.10.Гэнэтийн аюул осол тохиолдсон үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээг баримтжуулна.

Зургаа. Удирдлага, харилцаа холбоо

6.1.Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн системийн хэвийн болон ноцтой нөхцөл байдалд ажиллах горимыг төлөвлөгөөнд тодорхой тусгана. Үүнд:

6.1.1.Хариу арга хэмжээ;

6.1.2.Явцын хяналт-шинжилгээ;

6.1.3.Хангагч байгууллага, бусад оролцогч талуудын үүрэг, хариуцлага;

6.1.4.Харилцаа холбооны стратеги, төлөвлөгөө, мэдээлэх журам, ажиллагсдын холбоо барих мэдээлэл;

- 6.1.5.Ноцтой нөхцөл байдалд үйл ажиллагааг зохицуулах үүрэг, хариуцлага;
- 6.1.6.Хэрэглэгчид болон бусад оролцогч талд нөхцөл байдлын талаар мэдээлэх;
- 6.1.7.Баримт бичгийг шаардлагын дагуу шинэчлэх;
- 6.1.8.Ноцтой байдлын үед ундны усаар хангах төлөвлөгөө.

6.2.Баг нь жилд 2-оос доошгүй удаа уулзалт зохион байгуулан, төлөвлөгөөндөө тойм үнэлгээ хийнэ.

6.3.Тухайн цаг үеийн шаардлага болон ноцтой нөхцөл байдал үүссэн тохиолдолд төлөвлөгөөнд тойм үнэлгээ хийж, шинэчилнэ.

----oOo----